**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Сооро сейкео сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: БНА-2026/158/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2026.02.25<br>2026 | Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 99197196 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn<br>Ахлах аудитор М.Алтантуяа<br>Утас: 99061861 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Азбаяр<br>Утас: 99061429 Цахим хаяг: Azbayarb@audit.gov.mn<br>Цахим хуудас: www.audit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ **Error! Bookmark not defined.**
4. АУДИТЫН ТАЙЛАН ........ **Error! Bookmark not defined.**
4.1 Ерөнхий зүйл ........ **Error! Bookmark not defined.**
4.2 Материаллаг байдал ........ **Error! Bookmark not defined.**
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ **Error! Bookmark not defined.**
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .... **Error! Bookmark not defined.**
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ **Error! Bookmark not defined.**
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ **Error! Bookmark not defined.**
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 11
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 11
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 11

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/276
танай ____________-ны №____________-т

БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНХОНГОР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СООГО СЕЙКЕО СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Д.ЦЭДЭНСОДНОМ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Соого сейкео сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 640 хүүхдийн барилга баригдсаныг 2026 онд ашиглалтад хүлээн авсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Сургалтын үйл ажиллагаанд ашиглаж буй математик, англи хэлний хичээлийн программын үйлчилгээний төлбөрт тайлант онд хангамжид 26,600.3 мянган

Z:\Yawsan_Bichig\2026\0225 SAG-1.Docx

1526140528

төгрөг, төсвийн гүйцэтгэлийн сарын динамик мэдээний программд 160.0 мянган төгрөгийг төлж байгаа асуудлыг дээд шатны захирагч анхаарах шаардлагатай байна.

Дээд шатны захирагчийн дэргэдэх дотоод аудитын алба нь боловсролын байгууллагуудын урамшуулал олголтод хяналт хэрэгжүүлэхгүй байгаа нь тухайн асуудалтай холбоотой зөрчил арилахгүй, давтагдан гарах эрсдэлтэй байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудал**

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2026\0225 SAG-1.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **252,095,713.09** | **273,563,358.49** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | | 179,280,893.98 | 191,481,503.38 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | | 179,280,893.98 | 191,481,503.38 |
| **3121** | **Төгрөг** | | 179,280,893.98 | 191,481,503.38 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | | 179,280,893.98 | 191,481,503.38 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | | 72,814,819.11 | 82,081,855.11 |
| **351** | **Түүхий эд материал** | | 2,345,120.00 | 2,295,640.00 |
| 35130 | Эм боох материал | | 2,345,120.00 | 2,295,640.00 |
| **354** | **Хангамжийн материал** | | 70,469,699.11 | 79,786,215.11 |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 17,814,041.00 | 16,537,541.00 |
| 35420 | Аж ахуйн материал | | 51,814,658.11 | 62,478,674.11 |
| 35450 | Барилгын засварын материал | | 841,000.00 | 770,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | **1,426,390,747.87** | **1,331,749,960.11** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | | 1,426,390,747.87 | 1,331,749,960.11 |
| **392** | **Биет хөрөнгө** | | 1,217,561,303.41 | 1,123,067,182.29 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | | 966,092,361.00 | 966,092,361.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | | (152,967,786.21) | (181,816,641.09) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | | 464,197,937.52 | 472,199,560.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | (176,691,485.89) | (267,245,556.32) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 106,300,987.50 | 126,650,702.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | | (55,414,591.78) | (59,621,442.67) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | | 37,041,500.00 | 37,041,500.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | | (19,233,581.76) | (22,439,178.72) |
| 39217 | Ном | | 48,235,963.03 | 52,205,877.19 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | | 208,829,444.46 | 208,682,777.82 |
| 39301 | Програм хангамж | | 440,000.00 | 440,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | | (85,555.54) | (232,222.18) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | 208,475,000.00 | 208,475,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | **1,678,486,460.96** | **1,605,313,318.60** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **47,366,000.00** | **44,109,347.56** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | 47,366,000.00 | 44,109,347.56 |
| **413** | **Өглөг** | | 47,366,000.00 | 44,109,347.56 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | - | 4,109,347.56 |
| **4136** | **Бусад өглөг** | | 47,366,000.00 | 40,000,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | 47,366,000.00 | 40,000,000.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **1,631,120,460.96** | **1,561,203,971.04** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | 1,631,120,460.96 | 1,561,203,971.04 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 462,571,101.29 | 462,571,101.29 |
| 51101 | Өмч: - төрийн | | 462,571,101.29 | 462,571,101.29 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | | 678,283,377.94 | 609,115,579.19 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | 678,283,377.94 | 679,581,069.11 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | | (70,465,489.92) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 490,265,981.73 | 489,517,290.56 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | **1,678,486,460.96** | **1,605,313,318.60** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Тодруулга | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | | **2,204,208,138.00** | **2,702,637,614.16** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **107,702,738.00** | **5,869,914.16** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | 107,702,738.00 | 5,869,914.16 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 107,702,738.00 | 5,869,914.16 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 187,600.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 106,515,138.00 | 3,969,914.16 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | | 900,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **2,096,505,400.00** | **2,696,767,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | 1,948,134,200.00 | 2,536,009,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 1,948,134,200.00 | 2,536,009,300.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | 148,371,200.00 | 160,758,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | 148,371,200.00 | 160,758,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | | **2,291,270,984.58** | **2,773,103,104.08** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **2,291,270,984.58** | **2,773,103,104.08** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 2,181,690,115.95 | 2,581,005,434.58 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 1,574,356,997.00 | 1,936,214,629.00 |
| 210101 | Үндсэн цалин | | 1,038,235,684.00 | 1,262,928,726.00 |
| 210102 | Нэмэгдэл | | 480,671,813.00 | 579,600,463.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | - | 10,295,000.00 |
| 210104 | Урамшуулал | | 55,449,500.00 | 83,390,440.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 196,269,879.98 | 234,502,511.56 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 134,945,976.82 | 160,205,639.45 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 15,832,516.81 | 19,450,586.29 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 8,187,024.96 | 10,122,529.45 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 7,444,016.05 | 8,944,752.03 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 29,860,345.34 | 35,779,004.34 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 141,155,331.37 | 161,057,578.06 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 6,314,713.37 | 9,999,878.50 |
| 210302 | Түлш, халаалт | | 112,071,168.00 | 119,366,347.56 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 22,769,450.00 | 31,691,352.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 16,999,247.00 | 18,353,793.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 3,349,110.00 | 5,514,850.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 2,691,507.00 | 1,803,676.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | - | 60,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 1,200,000.00 | 1,300,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 9,758,630.00 | 9,675,267.00 |
| **2105** | **Нормативт зардал** | | 149,130.00 | 459,280.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 149,130.00 | 459,280.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 7,195,300.00 | 3,881,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 7,195,300.00 | 3,881,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 628,000.00 | 246,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 628,000.00 | 246,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 23,060,509.04 | 39,152,087.04 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 187,600.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 22,872,909.04 | 39,152,087.04 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 221,875,721.56 | 187,138,555.92 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 79,571,574.00 | 25,168,020.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 16,048,800.00 | 14,120,334.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 126,255,347.56 | 147,850,201.92 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 109,580,868.63 | 192,097,669.50 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 107,365,000.00 | 192,097,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | 95,869,500.00 | 161,415,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 11,495,500.00 | 30,682,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | | 2,215,868.63 | 169.50 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 2,215,868.63 | 169.50 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | | **(87,062,846.58)** | **(70,465,489.92)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | | **(87,062,846.58)** | **(70,465,489.92)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | тодруулга | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | | **2,097,693,000.00** | **2,697,767,700.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **1,187,600.00** | **1,000,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | 1,187,600.00 | 1,000,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | | 1,187,600.00 | 1,000,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 187,600.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **2,096,505,400.00** | **2,696,767,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | 1,948,134,200.00 | 2,536,009,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 1,948,134,200.00 | 2,536,009,300.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | 148,371,200.00 | 160,758,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | 148,371,200.00 | 160,758,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | | **2,124,257,867.02** | **2,636,327,590.60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **2,124,257,867.02** | **2,636,327,590.60** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **2,014,676,998.39** | **2,444,229,921.10** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 1,574,356,997.00 | 1,935,665,629.00 |
| 210101 | Үндсэн цалин | | 1,038,235,684.00 | 1,262,379,726.00 |
| 210102 | Нэмэгдэл | | 480,671,813.00 | 579,600,463.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | | 10,295,000.00 |
| 210104 | Урамшуулал | | 55,449,500.00 | 83,390,440.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 196,269,879.98 | 234,502,511.56 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 134,945,976.82 | 160,205,639.45 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 15,832,516.81 | 19,450,586.29 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 8,032,449.08 | 10,122,529.45 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 7,598,591.93 | 8,944,752.03 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 29,860,345.34 | 35,779,004.34 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 141,155,331.37 | 156,948,230.50 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 6,314,713.37 | 9,999,878.50 |
| 210302 | Түлш, халаалт | | 112,071,168.00 | 115,257,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 22,769,450.00 | 31,691,352.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 5,000,000.00 | 3,810,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 5,000,000.00 | 3,810,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 27,913,509.04 | 47,258,087.04 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 187,600.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 27,725,909.04 | 47,258,087.04 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 69,981,281.00 | 66,045,463.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 48,758,781.00 | 51,708,100.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 21,222,500.00 | 14,337,363.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **109,580,868.63** | **192,097,669.50** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 107,365,000.00 | 192,097,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | 95,869,500.00 | 161,415,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 11,495,500.00 | 30,682,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | | 2,215,868.63 | 169.50 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 2,215,868.63 | 169.50 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | | **(26,564,867.02)** | **61,440,109.40** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | | **65,294,810.00** | **49,239,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **65,294,810.00** | **49,239,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | | 65,294,810.00 | 49,239,500.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 65,294,810.00 | 49,239,500.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | | **(65,294,810.00)** | **(49,239,500.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | | (91,859,677.02) | 12,200,609.40 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 271,140,571.00 | 179,280,893.98 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 179,280,893.98 | 191,481,503.38 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **462,571,101.29** | **490,265,981.73** | **765,346,224.52** | **1,718,183,307.54** |
| Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | (87,062,846.58) | (87,062,846.58) |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **462,571,101.29** | **490,265,981.73** | **678,283,377.94** | **1,631,120,460.96** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 1,297,691.17 | 1,297,691.17 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **462,571,101.29** | **490,265,981.73** | **679,581,069.11** | **1,632,418,152.13** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | (748,691.17) | 0.00 | (748,691.17) |
| Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | (70,465,489.92) | (70,465,489.92) |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **462,571,101.29** | **489,517,290.56** | **609,115,579.19** | **1,561,203,971.04** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| **Эдийн засгийн ангилал** | **Төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,731,724,100.00 | 2,537,009,300.00 | 194,714,800.00 | 92.9 |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,546,443,200.00 | 2,536,009,300.00 | 10,433,900.00 | 99.6 |
| Улсын төсвөөс санхүүжих | 2,546,443,200.00 | 2,536,009,300.00 | 10,433,900.00 | 99.6 |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 185,280,900.00 | 1,000,000.00 | 184,280,900.00 | 0.5 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,000,000.00 | 1,000,000.00 | 5,000,000.00 | 16.7 |
| Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 179,280,900.00 | 0.00 | 179,280,900.00 | 0.0 |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,731,724,100.00 | 2,524,808,690.60 | 206,915,409.40 | 92.4 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,731,724,100.00 | 2,524,808,690.60 | 206,915,409.40 | 92.4 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,523,181,100.00 | 2,332,711,190.60 | 190,469,909.40 | 92.5 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,096,069,500.00 | 1,935,665,629.00 | 160,403,871.00 | 92.3 |
| Үндсэн цалин | 1,338,674,100.00 | 1,262,379,726.00 | 76,294,374.00 | 94.3 |
| Нэмэгдэл | 677,538,900.00 | 579,600,463.00 | 97,938,437.00 | 85.5 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 10,295,000.00 | -10,295,000.00 | |
| Урамшуулал | 79,856,500.00 | 83,390,440.00 | -3,533,940.00 | 104.4 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 262,008,800.00 | 234,502,511.56 | 27,506,288.44 | 89.5 |
| Тэтгэврийн даатгал | 178,165,900.00 | 160,205,639.45 | 17,960,260.55 | 89.9 |
| Тэтгэмжийн даатгал | 20,960,800.00 | 19,450,586.29 | 1,510,213.71 | 92.8 |
| ҮОМШӨ-ний даатгал | 10,480,400.00 | 10,122,529.45 | 357,870.55 | 96.6 |
| Ажилгүйдлийн даатгал | 10,480,400.00 | 8,944,752.03 | 1,535,647.97 | 85.3 |
| Эрүүл мэндийн даатгал | 41,921,300.00 | 35,779,004.34 | 6,142,295.66 | 85.3 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 49,240,400.00 | 47,258,087.04 | 1,982,312.96 | 96.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,000,000.00 | 0.00 | 5,000,000.00 | 0.0 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 44,240,400.00 | 47,258,087.04 | -3,017,687.04 | 106.8 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 115,862,400.00 | 115,284,963.00 | 577,437.00 | 99.5 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 101,525,000.00 | 100,947,600.00 | 577,400.00 | 99.4 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,337,400.00 | 14,337,363.00 | 37.00 | 100.0 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 208,543,000.00 | 192,097,500.00 | 16,445,500.00 | 92.1 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 208,543,000.00 | 192,097,500.00 | 16,445,500.00 | 92.1 |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 177,860,500.00 | 161,415,000.00 | 16,445,500.00 | 90.8 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 30,682,500.00 | 30,682,500.00 | 0.00 | 100.0 |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 | 0.00 | 100.0 |
| Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | 0.00 | 100.0 |
| **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 81.00 | 69.00 | 12.00 | 85.2 |
| Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | 0.00 | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 67.00 | 60.00 | 7.00 | 89.6 |
| Үйлчлэх ажилтан | 13.00 | 8.00 | 5.00 | 61.5 |

## 4. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 640 хүүхдийн барилга барьж 2026 онд ашиглалтад хүлээн авсан бөгөөд хөрөнгийн бүртгэлийн асуудлыг авч үзэх шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,238.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь материаллаг байдлын түвшингээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгөв.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1. Сургуулийн захирлын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн Б/76 дугаар тушаалаар гүйцэтгэлийн үнэлгээний 40.0 хувийн урамшууллыг бодож олгохдоо зөвхөн удирдлагын багийн гишүүдэд олгож, багшаас бусад албан хаагчдыг багшийн ангилалд оруулан 60.0 хувиар тооцон 2,238.1 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”-ын 3.4-т "Нэмэлт урамшууллын 65 хүртэлх хувийг албан хаагчдыг урамшуулахад зарцуулах бөгөөд урамшууллын хэмжээг ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнд үндэслэн доор дурдсан харьцааг баримтлан цэцэрлэг, сургуулийн зөвлөлөөр тус тус хэлэлцэж батална: 1. Удирдах ажилтан, бусад албан хаагч 40 хувь, 2. Багш нар 60 хувь” гэсэн заалтыг зөрчсөн байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Журам зөрчиж илүү олгосон 2,238.1 мянган төгрөгийн гүйцэтгэлийн урамшууллыг төсвийн захирагчаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Дээрх төлбөрийн актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Захирлын 2025 оны Б/76 дугаар тушаалаар гүйцэтгэлийн үнэлгээний 40 хувийн урамшууллыг бодож олгохдоо зөвхөн удирдлагын багийн гишүүдэд олгож, багшаас бусад албан хаагчдыг багшийн ангилалд оруулан 60 хувьд багтаан тооцож 2,238.1 мянган төгрөгийг удирдлагын болон бусад албан хаагчдад илүү олгосон байна. | 1 | 2,238.1 | 1 | 2,238.1 | | | | |
| **Нийт дүн** | **1** | **2,238.1** | **1** | **2,238.1** | | | | |

------------oOo-------------